



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын нэр: "Орон нутгийн төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудит

Аудитын код: ХӨА-2019/70/-ГА

Аймгийн ЗДТГ-ын Соёмбо танхимын засвар



Төсөвт өртөг :
436.5 сая төгрөг

Гүйцэтгэгч:
"Сондоргоо"
ХХК

Монгол Улсын Ерөнхий аудиторын Орлогчийн "Үндэсний аудитын газрын 2019 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай" 2019 оны А/03 дугаар тушаалын дагуу гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудит

"Ажилтай орлоготой Хөвсгөл" дэд хөтөлбөр



Төсөвт өртөг:
225.0 сая төгрөг

Гүйцэтгэгч:
Аймгийн ЗДТГ

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хяналт хангалтгүй байна.

Цэвэр ус зөөврийн машин



Төсөвт өртөг:
80.0 сая төгрөг

Гүйцэтгэгч:
"Бадрангуй орших" ХХК

Мөрөн 2019 он



Тайланг бэлтгэсэн:
Хөвсгөл аймаг дахь
Төрийн Аудитын газар

Тэргүүлэх аудитор

О.Ганболд

Аудитын менежер

Ж.Отгончимэг

Ахлах аудитор

Г.Эрдэнэчимэг

Аудитор

Л.Мандахнаран

З.Даваадорж

С.Гансүх

2019 оны 04 дүгээр
сар

Уг тайланг УАГ-ын Веб
сайт-аас үзнэ үү.

www.audit.mn

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70384043 дугаарын
утас, 70383793
дугаарын факсаар
харилцана уу?

ХАЯГ: (Хөвсгөл
аймгийн ЗДТГ-ын А
байр 3 давхарт)

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Ерөнхий зүйл

БҮЛЭГ-А. Зураг төсөв нь магадлал, хянан баталгаа хийгдээгүй арга хэмжээг төлөвлөж, баталсан байна.

- 1 Орон нутгийн хөрөнгө оруулалтыг хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлээгүй байна.
- 2 Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүд Хөвсгөл аймгийн бодлогын баримт бичигтэй нийцэж байна.
- 3 Зураг төсөв нь магадлал, хянан баталгаа хийгдээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж баталсан байна.

БҮЛЭГ-Б. ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын алба хууль, тогтоомжид заасан дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

- 1 Засаг даргын захирамжаар үнэлгээний хороо байгуулсныг эс тооцвол худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.
- 2 2018 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний биелэлт 92.2 хувьтай байна.
- 3 Захиалагчийн зүгээс гэрээний хэрэгжилтэд хийсэн хяналт үр дүнгүй байна.
- 4 Санхүүгийн хяналт, аудитын алба Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 5.2.4 -д заасан чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.

БҮЛЭГ-В: 2018 онд Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, хөтөлбөр тус бүрээр хяналт, үнэлгээ хийгээгүй байна

- 1 2018 онд Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээ бүрээр хэрэгжилт, үр дүнг тооцож, үнэлгээ хийж ажиллаагүй байна.
- 2 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал

Хавсралт

Зөрчлийн жагсаалт.....

Тэргүүлэх аудиторын тушаал.....

Товчилсон үгийн тайлбар

Товчилсон үг	Тайлбар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ТХОТСХТЖ	Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ААН	Аж ахуйн нэгж
ТАХ	Төсөл арга хэмжээ
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ОБГ	Онцгой байдлын газар
ХШУДАХ	Хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт

Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн байна уу?
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцсон байна уу?

Аудитын хамрах хүрээ

2018 онд аймгийн ИТХ-аас нийт хөрөнгө оруулалтын төсвийн 70%-ийг аймагт, 30%-ийг сумдад хуваарилсан байна. Аудитаар аймагт хуваарилсан төсвөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээг хамруулан аймгийн ИТХ, ОНӨГ, ГХБХБГ, СХАА, ЗДТГ-ын ХШУДАХ, ХОХБТХ, СТСХ, сумдын ИТХ болон ЗДТГ, холбогдох байгууллагууд, зарим гүйцэтгэгч ААН-ийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын журмыг мөрдөж, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, холбогдох асуудлаар аудитад хамрагдсан байгууллага болон ОНӨГ-ын дарга болон холбогдох ажилтан албан хаагчидтай уулзаж санал солилцож, тайлбар гаргуулан, амаар зөвлөмж өгч, ОНӨГ, ЗДТГ-ын СТСХ, ХОХБТХ-ийн гаргасан судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулан ажиллалаа.

Шалгуур үзүүлэлтүүд

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамжид заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашигласан. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Өрийн удирдлагын тухай хууль
- Сангийн Сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан ТХОТСХТ журам
- Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан ТБОНӨХБАУХА ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам.

- Сангийн сайдын 2018 оны 281 тушаалаар батлагдсан ТБОНӨХБАУХА ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын нэмэлт өөрчлөлт
- Аймгийн ИТХ-ын хуралдааны баталсан, тодотгосон тогтоолууд
- Холбогдох бусад хууль, журам, шийдвэр

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор О.Ганболд удирдан, Аудитын менежер Ж.Отгончимэг аудитын арга зүйгээр хангаж, үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитор С.Гансүх, Л.Мандахнаран, З.Даваадорж нар гүйцэтгэв.

Ерөнхий зүйл:

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 61 төсөл, арга хэмжээг 3,616.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр, аймгийн замын сангийн хөрөнгөөр нийт 8 төсөл, арга хэмжээг 496.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тус тус баталсан¹ байна. Эдгээр төсөл, арга хэмжээг ангилж хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1: ТАХ-ний ангилал

Орон нутгийн хөрөнгө оруулалт		Тоо	Тайлбар
1	Тайланд онд шинээр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ	54	Хэрэгжсэн 49, хэрэгжээгүй 2, 2019 онд үргэлжлэн хэрэгжих 3 төсөл арга хэмжээ байна.
2	Өмнөх оноос тайлант онд үргэлжлэн хэрэгжсэн.	7	Бүрэн хэрэгжсэн
Аймгийн замын сан			
1	Тайланд онд шинээр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ	7	Хэрэгжсэн 6, 2019 онд үргэлжлэн хэрэгжих 1 төсөл арга хэмжээ байна.
2	Өмнөх оноос тайлант онд үргэлжлэн хэрэгжсэн.	1	Бүрэн хэрэгжсэн
Нийт		69	



Шинээр хэрэгжүүлсэн нийт төсөл, арга хэмжээний 16.9 хувь нь барилга байгууламжийн засварын ажил, 16.9 хувь нь тоног төхөөрөмж худалдан авах ажиллагаа, 11.9 хувь нь барилга байгууламж шинээр барих, 54.3 хувь нь хөтөлбөр, бусад арга хэмжээ байна.

Аймгийн Засаг дарга орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнээс нийт 276.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 арга хэмжээний эрхийг

тухайн арга хэмжээ хэрэгжих сумдын Засаг дарга нарт шилжүүлсэн байна.

¹ Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн ээлжит 5 дугаар хуралдааны 06 дугаар тогтоол, аймгийн ИТХ-ын 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит 6 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоол, аймгийн ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 9 дүгээр хуралдааны 06 дугаар тогтоол.

Бүлэг А: Зураг, төсөв нь магадлал, хянан баталгаа хийгдээгүй арга хэмжээг төлөвлөж, баталсан байна.

А.1 Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүдийг хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлээгүй байна.

АИТХ-аар батлагдсан орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2018 онд нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэл болон Хөвсгөл аймгийн 2017-2020 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй нийцэж байгаа боловч Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт тайлагналтын журам"-ын 3 дахь хэсгийн 3.6²-д зааснаар хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлээгүй байна.

А.2 Зураг төсөвт магадлал хийгдээгүй төсөл арга хэмжээг төлөвлөж баталсан байна.



Зураг, төсөвт нь магадлал хийгдээгүй 12 /хүснэгт 2-оор харуулав/ төсөл арга хэмжээний төсвийг ИТХ-ын хуралдаанаар баталж Монгол улсын Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4³ дэх заалтыг зөрчсөн байна. Дээрх зөрчилд аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг даргад

зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Хүснэгт 2 /сая төгрөг/

A	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая төгрөг/	Төсөв баталсан огноо	Зураг, төсөвт магадлал хийгдсэн огноо
Орон нутгийн хөрөнгө оруулалтаар				
1	Онцгой байдлын газрын барилгын гадна дулааны ажлыг дуусгахад шаардлагатай нэмэлт ажил	26.5	2017.12.04	2018.05.24
2	Авъяас сургуулийн барилгын ариун цэврийн байгууламжийн нэмэлт ажил	13.8	2017.12.04	2018.05.24
3	Орон сууцны байруудыг хэрэглээний халуун усны системд холбох ажлын зураг төсөв /Мөрөн сум/	56.2	2017.12.04	2017.12.05
4	Бүрэнхаан цэцэрлэгийн их засварын ажил /Мөрөн сум/	282.8	2017.12.04	2018.02.14
5	Нэгдсэн эмнэлгийн хөдөлмөр магадлах комиссын өрөөний засвар	14.0	2018.02.07	2018.07.09
6	Шаардлагатай газруудад гүний худаг гаргах /Гөмөрбулаг, Баянзүрх, Чандмань-Өндөр, Рашаант, Түнэл/	100.0	2017.12.04	2018.06.27

² ТЕЗ, аймаг, нийслэлийн тухайн санхүүгийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь тухайн захиалагчийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй харилцан уялдсан байхын зэрэгцээ салбарын гол тэргүүлэх чиглэл, хөрөнгө оруулалтын ач холбогдол, тухайн төслийн хэрэгжилттэй уялдуулан эрэмбэлсэн байна.

³ Хөрөнгө оруулалтын төсөвт төхник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөөвө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

7	Чингүнжавын талбайн индрийн засвар /Мөрөн сум/	51.5	2018.02.07	2018.06.27
8	100 хүүхдийн цэцэрлэг /5 дугаар цэцэрлэг/-ийн өргөтгөлийн барилгын ажил	1,161.5	2018.02.07	2018.06.25
9	Мөрөн сумын баяр наадмын талбайн төв хаалганы урд барих авто замын зогсоолын ажил	88.4	2018.02.07	2018.04.13
10	3 хүний халуун ус барих /Алаг-Эрдэнэ сум/	80.0	2018.02.07	Зураг төсөв хийгдээгүй
11	Багийн мэдээллийн төвийн барилга /Рашаант сум/	38.6	2018.02.07	Зураг төсөв байхгүй
Замын сангийн хөрөнгө оруулалт				
12	Шаардлагатай газруудад гэрлэн дохио суурилуулах /Мөрөн сум/	60.0	2017.12.04	2018.09.28
Нийт		1,973.3		

БҮЛЭГ-Б. ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын алба хууль, тогтоомжид заасан дотоод хяналтын чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.

Б.1 Засаг даргын захирамжаар үнэлгээний хороо байгуулсныг эс тооцвол худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

Аймгийн Засаг дарга А/204 тоот захирамжаар төсөв батлагдсанаас хойш 102 хоног, төсөвт тодотгол орсноос хойш 37 хоногийн дараа арга хэмжээ хэрэгжих сумдын Засаг дарга нарт эрх шилжүүлсэн нь нь Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14 өдрийн 363 дугаар тушаалын 2.11⁴ дахь заалтыг зөрчсөн байна. Дээрх зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

39 төсөл арга хэмжээний үнэлгээний хороог аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2⁵ дахь заалтыг зөрчсөн байна. Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хүрээнд 2018 оны 1 дүгээр улирлаас дээрх зөрчлийг арилгаж ажилласан байна.

Аймгийн Засаг даргын захирамж, аймгийн ЗДТГ-ын тушаалаар байгуулагдсан "Үнэлгээний хороо" нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна. Худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг өмнөх онтой харьцуулж хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3

№	Эх үүсвэр	Нээлттэй тендер шалгаруулалт		Харьцуулалтын арга		Шууд худалдан авалт		Хязгаарлагдмал	
		2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
1	Орон нутгийн хөрөнгө оруулалт	11	12	16	43	0	1	0	0
2	Замын сангийн хөрөнгө	1	3	10	3	0	0	2	0
Нийт		12	15	26	46	0	1	2	0

⁴Захиалагч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46.3-т заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, хэрэв тодотгол орсон бол түүнээс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байх /Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 261 дүгээр тушаалаар баталсан журмын 2.13 болж өөрчлөгдсөн./

⁵45.2.2 аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь тухайн орон нутагт худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд захиалагч нь байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2018 онд аймгийн Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 7 төсөл, арга хэмжээ, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 48 нийт 55 төсөл арга хэмжээний 52 худалдан авах үйл ажиллагааг “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ыг баримтлан цахим хэлбэрээр зохион байгуулж гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй, өрсөлдөх боломжоор хангаж ажилласан байна. 3 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг техникийн саатлаас шалтгаалж цаасаар зохион байгуулсан. /6 төсөл арга хэмээ суманд эрх шилжсэн/

Худалдан авах ажиллагаанаас нийт 402.7 сая төгрөгийн тендерийн хэмнэлт бий болгосон байна.

Аймгийн ОНӨГ нь 2018 оны худалдан авах ажиллагааны тайланд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 7 /хүснэгт 4-өөр харуулав/ төсөл, арга хэмжээг тайлагнаагүй байна. Илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Хүснэгт 4 /сая төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	
		ХАА-ны төлөвлөгөөнд тусгасан төсөвт өртөг	Шалгарсан төсөвт өртөг
1	Нэгдсэн эмнэлгийн төв корпусын барилгын их засварын ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ	14.0	13.5
2	Жаргалант сумын Зөөлөнгийн даваа, Шинэ-Идэр сумын Шивэрт, Бумбатын даваа. Баянзүрх сумын Эмтийн давааны зам гүүрийн засварын ажлын зураг боловсруулах зөвлөх үйлчилгээ	35.0	25.0
3	Мөрөн 17,18 дугаар байрнуудын дээврийг засварлах ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ	4.0	4.0
4	Мөрөн сумын орон сууцны 17 дугаар байрны гадна тохижилт гэрэлтүүлэг хийх ажлын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээ	2.0	1.9
5	Рашаант, Цэцэрлэг, Ханх, Баянзүрх сумдын ЗДТГазрын барилгын холболтын зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэл, төсөв боловсруулахад шаардлагатай хөрсний инженер геологийн дүгнэлт гаргаж ажил	12.0	12.0
6	Багц 1: Бүрэнтогтох сумын 150 хүүхдийн цэцэрлэг барих ажлын зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэл, төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээ	20.0	18.0
	Багц 2: Бүрэнтогтох сумын 150 хүүхдийн цэцэрлэг барих ажлын зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэл, төсөв боловсруулахад шаардлагатай хөрсний инженер геологийн дүгнэлт гаргах	2.0	2.0
7	Багц 1: Баянзүрх сумын 150 хүүхдийн цэцэрлэг барих ажлын зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэл, төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ	22.0	22.0
	Багц 2: Баянзүрх сумын 150 хүүхдийн цэцэрлэг барих ажлын зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэл, төсөл боловсруулахад шаардлагатай хөрсний инженерийн дүгнэлт гаргах ажил	3.0	3.0
Нийт дүн		114.0	101.4

Б.2 2018 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний биелэлт 92.2 хувь байна.

Аймгийн ИТХ-аар батлагдсан орон нутгийн хөрөнгө оруулалтын нийт 61 төсөл арга хэмжээнээс 59 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэгч нарт 3,546.0 сая төгрөг, замын сангийн хөрөнгөөр 8 төсөл арга хэмжээнээс 5 төсөл арга хэмжээ хэрэгжүүлж гүйцэтгэгч нарт 366.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Ренчинлхүмбэ сумын Сант-Жиглэгийн давааны зам засварын барилгын ажлыг эс тооцвол тендерээр шалгарсан аж ахуй нэгжүүд гэрээний дагуу хугацаанд нь гүйцэтгэсэн байна. Ренчинлхүмбэ сумын 4 дүгээр баг Сант-Жиглэгийн давааны 0.6 км хайрган хучилттай авто замын барилгын ажилд 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдөр тендер зарлаж 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр сонгон шалгаруулалт хийж, 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдөр "Хөвсгөл зам" ХХК-тай ХӨ-2018/4.4.1-А/01 дугаартай гэрээ байгуулсан. Замын нөхцөл муугаас шалтгаалан гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлэхээс татгалзсан тул аймгийн ЗДТГ-ын даргын 2018 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн А/157 тоот тушаалаар гэрээг цуцалсан. Тус компанийн гүйцэтгэлийн баталгаа болох 6.9 сая төгрөгийг гэрээний үүргээ биелүүлээгүй гэх үндэслэлээр улсын орлого болгохоор ОНӨГ-аас шийдвэрлэжээ.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажилласан байна. 2018 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний биелэлт 92.2 хувь байна

Б.3 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн захиалагчийн хяналтын ажлыг тайлагнаагүй байна.

Төслийн багийг Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар төслийн менежер болон гишүүдийг зохиогч, гүйцэтгэгч, хэрэглэгч, мэргэжлийн хяналт болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөлөл оролцуулан байгуулсан байна.

Төслийн баг гүйцэтгэгчийн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд явцын хяналт хийсэн боловч баримтжуулалт хангалтгүй байна. Тодруулбал: Төслийн баг байгуулсан шийдвэр бүрд гэрээний хэрэгжилтэд захиалагчийн хяналт тавих, гэрээ дүгнэх, барилга угсралтын ажлыг хүлээн авах үйл ажиллагааг хууль дүрмийн дагуу зохион байгуулахыг төслийн менежер, барилга угсралтын ажлыг холбогдох данс бүртгэлд тусгахыг аймгийн ОНӨГ-ын дарга, ил далд ажлын акт, гэрээний хэрэгжилтийн мэдээлэл, гэрээ дүгнэх акт, ажил хүлээн авсан акт болон гүйцэтгэлийн баримт бичиг, төслийн багийн хурлын тэмдэглэл, шийдвэр зэргийг хууль журмын дагуу худалдан авах ажиллагааны баримт бичигт архивлан, тайлагнахыг төслийн багийн нарийн бичгийн даргад тус тус даалгасан байна. Гэсэн хэдий ч энэхүү шийдвэр бүрд даалгасан баримт бичгийг холбогдох албан тушаалтнууд архивын нэгж болгон хадгалж, тайлагнаагүй байна.

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ ЗГ-ын 2017 оны 170⁶ дугаар тогтоолоор баталсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн өөрчлөлтүүдийг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

⁶ Засгийн газрын 2018 оны 316 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон

Б.4 Санхүүгийн хяналт, аудитын алба Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын 5.2.4 -д заасан чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.

Санхүү, төрийн сангийн хэлтсээс төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо захиалагч болон гүйцэтгэгчээс ирүүлсэн баримтыг үндэслэн гүйлгээг хийсэн байна.

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд дотоод хяналтыг хийгээгүй, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын 5.2.4⁷-д заасан чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна. Энэ зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

БҮЛЭГ В: 2018 онд Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, хөтөлбөр тус бүрээр хяналт, үнэлгээ хийгээгүй байна

В.1 2018 онд Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээ бүрээр хэрэгжилт, үр дүнг тооцож, үнэлгээ хийж ажиллаагүй байна.

Хөвсгөл аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг аймгийн ТЭЗ нь батлуулахдаа тухайн оны хөрөнгө оруулалтын хүрэх зорилт, үр дүнг тооцож батлуулсан байна.

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 1 дэх хэсгийн 1.3. “Энэхүү журмыг Улсын болон **орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт**, төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй бүх хөрөнгө оруулалт, “Барих-шилжүүлэх” концессын төслийн эргэн төлөлт, улсын төсвийн бүрэлдэхүүнд ордог Засгийн газрын тусгай зориулалтын сангуудын хөрөнгөөр хэрэгжүүлэх барилга байгууламж, тоног төхөөрөмж, их засвар, бараа, ажил үйлчилгээ, ТЭЗҮ, зураг төсвийн ажлыг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнахад **мөрдлөг** болгоно.”, 6 дахь хэсгийн 6.2 “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн багцад батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн тайланг сар бүр энэ журмын 6 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргаж, дараа сарын 5-ны дотор Сангийн яаманд хүргүүлнэ.” гэж заасны дагуу аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар тайлан гаргаагүй байна. Хэрэгжилтийн тайланг гаргаагүйн улмаас холбогдох шатны хяналт хийх, үнэлгээ өгөх эрх бүхий байгууллагаас хяналт, үнэлгээ өгөх боломжгүй болсон байна.

ХШҮДАХ нь Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3 дахь хэсгийн 3.2⁸-т заасан 3.2.2.9⁹, 3.2.2.10¹⁰ дахь заалтуудын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ төсөл, хөтөлбөр тус бүрээр үнэлгээ хийгээгүй байна. ХШҮДАХ-ээс ирсэн тайлбарт үндэслэн дээрх зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв

⁷Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих

⁸Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээнд дараах бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, захиргааны байгууллагын үйл ажиллагаа багтана

⁹Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр

¹⁰Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

В.2 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна

Өмнөх аудитаар өгсөн 9 зөвлөмжөөс 2 зөвлөмж биелж, 4 зөвлөмжийг дутуу биелүүлж, 3 зөвлөмжийг биелүүлээгүй гэж үзлээ. Зөвлөмжийн биелэлтийг хүснэгтээр харуулбал:

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж		Зөвлөмжийн биелэлт / аудитын үр дүн/	Хүснэгт 5 Биелэлтийн үнэлгээ /Хангалттай дутуу, хангалтгүй/
Аймгийн ИТХ-ын дарга Л.Төмөрбаатарт	Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт тусгагдаагүй, ТЭЗҮ, зураг, төсөв хийгдээгүй төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэхгүй, батлахгүй байх.	АИТХ-аас 2018 онд зураг төсөвгүй 12 төсөл арга хэмжээний төсвийг хэлэлцэн баталсан байна.	Дутуу
Аймгийн Засаг дарга Л.Ганболдод	1. Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт тусгагдсан, ТЭЗҮ, зураг, төсөв нь хийгдсэн төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын хуралдаанд өргөн мэдүүлж батлуулахад гарсан зөрчлийг арилгах талаар өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцон ажиллах	АИТХ-д зураг төсөвгүй 12 арга хэмжээ өргөн барьж батлуулсан.	Дутуу
	2. "Авто замын мастер төлөвлөгөө"-г боловсруулж, аймгийн ИТХ-аар батлуулах.	"Авто замын мастер төлөвлөгөө" АИТХ-аар батлуулаагүй байна.	Хангалтгүй
Аймгийн ЗДТГ-ын дарга Х.Ган-Очирт	1. Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтийг хангуулах, гэрээний хугацаанд хэрэгжихгүй болсон үед шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ашиглалтад оруулах, хуулинд заасан өөрийн бүрэн эрхийг бодит утгаар нь хэрэгжүүлж ажиллах	2018 онд гэрээ гүйцэтгэл хэрэгжээгүй тохиолдол гараагүй байна.	Хангалттай
	2. Захиалагчийн хяналтын зардлыг зарцуулах журам боловсруулан батлуулж, зардлыг үр дүнтэй, үр ашигтай зарцуулах.	Журмыг Хөвсгөл аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2018 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 57 дугаар тогтоолоор баталсан.	Хангалттай
	3. ЗДТГ-ын ХОХБТХ, ХШҮДАХ, ОНӨГ, СХАА-ны ажилтан албан хаагчдын ажлын уялдаа холбоог сайжруулж, хариуцлагын арга хэмжээ авч ажиллах	ХОХБТХ-ийн зүгээс зураг төсөвгүй төсөл арга хэмжээг төлөвлөсөн, ОНӨГ-аас тус төсөл арга хэмжээнүүдэд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан, ХШҮДАХ, СХХА-аас хяналт, шинжилгээ хийгээгүй харилцан уялдан ажиллаагүй байна.	Дутуу
Аймгийн ОНӨГ-ын дарга Б.Болдод	Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг үнэн зөв бодитой тайлагнах, журмын дагуу дотоод	Худалдан авах ажиллагааны тайланг тулган хянахад 2018	Хангалтгүй

	аудитын дүгнэлт гаргуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх	оны жилийн эцсийн тайланд 7 худалдан авах ажиллагааг тайлагнаагүй байна.	
Аймгийн ЗДТГ-ын дарга ХШУДАХ-ийн дарга Ч.Уртнасанд:	МУ-ын Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 4.1. (Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд журмын 2 дугаар хавсралтаар батлагдсан үнэлгээний аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.)-ийг хэрэгжүүлж ажиллах	ХШУДАХ-ээс хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.	Дутуу
Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга В.Нэргүйд:	Худалдан авах ажиллагааны жилийн эцсийн тайланд хяналт шалгалт хийж бодит дүгнэлт гаргах, ажлын хариуцлага алдсан албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллах	2018 оны ажлын төлөвлөгөөнд худалдан авах ажиллагааны жилийн эцсийн тайланд хяналт шалгалт хийх ажлыг тусгаж өгөөгүй байна.	Хангалтгүй

ДҮГНЭЛТ

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгцээ, шаардлагын дагуу эрэмбэлээгүй, зураг төсөвт магадлал хийгдээгүй төсөл арга хэмжээг баталсан байгаа нь шаардлагатай хөрөнгө оруулалт мөн эсэхийг тодорхойлох боломжгүй, төсөл, арга хэмжээ үндэслэлгүй төлөвлөх эрсдэл бий болгосон байна.
2. Сумдын Засаг дарга нарт худалдан авах ажиллагааны эрх шилжүүлэхдээ Сангийн сайдын 2018 оны 363 тоот тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.13 дахь заалтыг зөрчиж хугацаа хоцроож эрх шилжүүлсэн нь төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжих боломжгүй болгох эрсдэл үүсгэж байна.
3. Аймгийн ОНӨГ нь 2018 оны худалдан авах ажиллагааны тайланд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 7 арга хэмжээг орхигдуулан мэдээлсэн байна.
4. Захиалагчийн хяналт хариуцсан мэргэжилтэн, төслийн баг нь төсөл, арга хэмжээний үе шатны ажлын хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.
5. Санхүүгийн хяналт, аудитын алба нь Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээнд дотоод хяналтыг хийгээгүй байгаа нь Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.2.4-д заалтыг зөрчиж төсвийн ерөнхийлөн захирагчийн орон нутгийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хийх хяналтыг сулруулсан үйлдэл болсон байна.
6. ХОХБТХ нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын

журам"-ын 6.2¹¹-т заасны дагуу орон хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг тайлагнаагүй байгаа учир хэрэгжилтийг хяналт, үнэлгээ хийх эрх бүхий байгууллагаас үнэлэх боломжгүй болсон байна.

7. ХШУДАХ нь Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 3 дахь хэсгийн 3.2¹²-т заасан 3.2.2.9¹³, 3.2.2.10¹⁴ дахь заалтуудын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр бүрэн хэмжээнд үнэлгээ хийгээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Л.Төмөрбаатарт:

1. Зураг, төсөвт магадлал хийгдээгүй төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэхгүй, батлахгүй байх

Аймгийн Засаг дарга Л.Ганболдод:

1. Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт тусгагдсан зураг, төсөв нь батлагдаагүй төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын хуралдаанд өргөн мэдүүлж батлуулсан зөрчлийг арилгах, энэ талаар өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцон ажиллах
2. Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлэхдээ Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг төлөвлөх тайлагнах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.13 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах

Аймгийн ЗДТГ-ын дарга Х.Ган-Очирт:

1. Захиалагчийн үе шатны ажлын хяналтыг хэрэгжүүлсэн ажлыг холбогдох газруудад тайлагнаж ажиллах
2. Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ ЗГ-ын 2017 оны 170¹⁵ дугаар тогтоолоор баталсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн өөрчлөлтүүдийг мөрдөж ажиллах

Аймгийн ОНӨГ-ын дарга Б.Болдод:

1. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг үнэн зөв тайлагнаж ажиллах

¹¹ Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн багцад батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн тайланг сар бүр энэ журмын зургаадугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргаж, дараа сарын 5-ны дотор Сангийн яаманд хүргүүлнэ

¹² Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээнд дараах бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, захиргааны байгууллагын үйл ажиллагаа багтана

¹³ Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр

¹⁴ Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

¹⁵ Засгийн газрын 2018 оны 316 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Э.Азаяад:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлэх
2. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг холбогдох газруудад хүргүүлж ажиллах
3. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа зураг, төсөв нь магадлал хийгдсэн төсөл, арга хэмжээг тусгах

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Г.Энхбаярт:

1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ төсөл, хөтөлбөр тус бүрээр бүрэн хэмжээнд үнэлгээ хийж ажиллах

Илэрсэн зөрчлийн жагсаалт

№	Илэрсэн зөрчлийн		Өгсөн албан шаардлага		Тавьсан акт		Өгсөн зөвлөмж	
	Утга	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээг хэрэгцээ, шаардлагын дагуу эрэмбэлээгүй байна.						1	
2	Магадлал хийгдээгүй зураг, төсөвтэй 12 төсөл арга хэмжээний төсвийг АИТХ-аар баталсан байна.	1,973.3					3	1,973.3
3	Захиалагч нь худалдан авах ажиллагааны эрх шилжүүлэхдээ эрх шилжүүлэх хугацаа баримтлаагүй байна.	276.2					2	276.2
4	Худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв тайлагнаагүй байна.	114.0					1	114.0
5	Орон нутгийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн тайлан гаргаагүй байна.						2	
6	ТЕЗ дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.		1					
7	ЗДТГ-ын ХШУДАХ хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд төсөл, хөтөлбөр тус бүрээр үнэлгээ өгөөгүй байна.						1	
Нийт		2,363.5	1				10	2,363.5

Хүснэгт 6 /сая төгрөгөөр/